



Japan
Fund for
Poverty
Reduction



L3605/G9191 : MON48076 - ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

СТВ- ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ, ЯДУУРЛЫН СТАТИСТИКИЙН АХЛАХ ЗӨВЛӨХ

А. ТАНИЛЦУУЛГА

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр Монгол Улсын Засгийн газар (Зээлийн дугаар 3605) “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл” (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлж байна. Тус төсөл нь Улаанбаатар хот болон аймгуудын түвшинд ХБИ-дэд чиглэсэн үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, ХБИ-ийн бие даан амьдрах чадварыг дээшлүүлж, нийгэм, эдийн засагт тэдний оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэхийн тулд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой юм. Холбогдох мэдээллийг доорх линкээр орж харна уу.

<https://www.adb.org/sites/default/files/project-documents/48076/48076-002-rrp-en.pdf>

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь хөгжлийн бэрхшээлийн олон улсын түвшинд харьцуулагдахуйц тоо мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийхэд Үндэсний Статистикийн Хороонд дэмжлэг үзүүлэх зорилгоор гадаад болон дотоод нэг зөвлөхийг сонгон ажиллах юм. ХНХЯ зөвлөхүүдийг Азийн Хөгжлийн Банкны “Зөвлөхийг ашиглах журам”-д заасны дагуу сонгон шалгаруулна.

Б. ЗӨВЛӨХ АЖЛЫН ЗОРИЛТУУД

1. Өрхийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн судалгаа болон бусад судалгааг үнэлсний үндсэн дээр Вашингтон бүлгийн арга зүйг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны түвшин, орлогын түвшин болон нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдалтын талаарх тоон мэдээлэл цуглуулах, судалгааны асуултууд боловсруулах, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлалын талаар санал зөвлөмж боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
2. Хөгжлийн бэрхшээлийн статистикийг сайжруулах, асрамжийн байгууллагуудад үйлчлүүлэгчдийн мэдээллийн сан байгуулах, ҮСХ болон бусад холбогдох талуудын чадавх бэхжүүлэхэд удирдамжаар хангах, асрамжийн байгууллагуудад үйлчлүүлэгчдийн судалгаа явуулахад ҮСХ-нд дэмжлэг үзүүлэх;

В. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ХҮРЭЭ

Зорилт 1-ийн хүрээнд:

1.1. Вашингтон бүлгийн зөвлөмж болгосон хөгжлийн бэрхшээлийн багц асуулгыг ашиглаж байгаа Өрхийн Нийгэм Эдийн Засгийн Судалгаа болон бусад судалгааны үр дүн, статистик тоон мэдээлэл цуглуулах;

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааны түвшин, ядуурлын түвшин болон тэдгээрийн нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдалтыг тооцох шинэ эсвэл сайжруулсан багц асуулга/арга зүйг боловсруулах, амьжиргааны түвшин, ядуурлын түвшингийн үзүүлэлтүүдийн тайлангийн загварыг бэлтгэхэд Зөвлөхөд дэмжлэг үзүүлэх;

1.3. Вашингтон бүлгийн асуулгыг бусад судалгаанд нэвтрүүлэх, холбогдох дүн шинжилгээ, хэвлэгдэх тайланд хэрхэн тусгах талаар санал боловсруулах;

Зорилт 2-ын хүрээнд:

2.1. Хөгжлийн бэрхшээлийн статистик болон мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх механизмын талаар судалгаа хийх;

2.2. Хөгжлийн бэрхшээлийн статистик тоон мэдээллийг сайжруулах, асрамжийн байгууллагуудад үйлчлүүлэгчдийн мэдээллийн сан байгуулах удирдамж боловсруулахад гадаад Зөвлөхөд дэмжлэг үзүүлэх;

2.3. Хөгжлийн бэрхшээлийн талаарх тоон мэдээлэл, судалгааг ашиглах арга зүйн сургалтын хөтөлбөр, модуль болон сургалтад ашиглах гарын авлага, материалыг бэлтгэх, сургалт зохион байгуулахад гадаад зөвлөхөд дэмжлэг үзүүлэх;

Зорилт 3-ын хүрээнд:

3.1. Инчеоны Стратеги болон бусад бодлогын баримт бичгүүдийн үзүүлэлтүүдийг тооцоход шаардлагатай бүх мэдээллийг цуглуулах;

3.2. Инчеоны Стратегийн хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүдийг тооцон тайлан гаргахад гадаад Зөвлөхөд дэмжлэг үзүүлэх;

3.3. Инчеоны Стратегийн хэрэгжилтийн мониторингийн хийх чадавхыг бэхжүүлэх сургалтын хөтөлбөр, модуль болон сургалтын материал, гарын авлага бэлтгэхэд Зөвлөхөд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулахад туслан дэмжих.

Г. ХЯНАЛТ, ТАЙЛАН:

Зөвлөх нь ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн газар /ХАХГ/-ын дарга болон Төслийн зохицуулагчид ажлаа тайлагнана. Ажлын даалгавартай холбогдох зохицуулалтын асуудлыг ХАХГ-ын дарга, ХНХЯ болон ҮСХ-ны мэргэжилтнүүдтэй зөвшилцөнө. Ажлын явцын тайланг ажлын хэсгийн хуралд танилцуулна /шаардлагатай бол бусад уулзалтаар/.

Захиалагч нь зөвлөхийн гүйцэтгэлийг үнэлж, бүрэн гүйцэтгэсэн ажлын нэхэмжлэхийг батална.

Зөвлөхийг ажлаа эхлүүлснээс хойш долоо хоногийн дотор Захиалагч нь ажлын төлөвлөгөөг батлах бөгөөд энэ төлөвлөгөөг зөвлөх үйлчилгээний туршид төлөвлөсөн үр дүнгийн явцыг дүгнэхэд ашиглана.

Зөвлөх нь ажлын даалгаврыг үр дүнтэй хэрэгжүүлэх явцад гарсан ололт амжилт, бэрхшээлийг нарийвчлан тусгасан явцын хураангуй тайлан бэлтгэн хүргүүлнэ.

Захиалагч болон ТХН нь зөвлөхийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд оролцох бөгөөд эцсийн тайланг ХНХЯ, ҮСХ болон ТХН-д цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Зөвлөх нь дотоодын зөвлөхтэй баг болон хамтран ажиллана.

Гадаад зөвлөхөд дэмжлэг тусалцаа үзүүлэн, хамтарч ажиллах, үүнд (i) (C) хэсэгт дурдсан ажлын даалгаврууд гүйцэтгэх; (ii) өөрийн орны хууль эрх зүйн орчин, дүрэм журмыг ойлгоход нь гадаад зөвлөхөд туслан дэмжих; (iii) гадаад зөвлөхийн хүсэлтийн дагуу холбогдох баримт бичгийг цуглуулах, материалаар хангах; (iv) гадаад зөвлөхтэй Монголын нөхцөлд тохирсон санал боловсруулахад нь хамтран ажиллах; (v) гадаад зөвлөх байхгүй хугацаанд зуучлагчийн үүрэгтэй

ажиллах; (vi) гадаад зөвлөхөд аман болон бичгийн орчуулга хийх.

Зөвлөх нь ажлын даалгавартай холбогдох зохицуулалт болон зохион байгуулалтын асуудлаар гадаадын зөвлөх болон төслийн захирлын томилсон холбогдох мэргэжилтнүүдтэй өдөр тутам хамтран ажиллана.

Захиалагч нь гадаад зөвлөхөд дотоодын зөвлөх болон гэрээнд заасан бүтээгдэхүүнийг хүлээн авах ажилтнуудтай ажиллахад нь ТХН дээр ажлын өрөөгөөр хангана.

Зөвлөх нь ажлын даалгавартай холбогдох зохицуулалт болон зохион байгуулалтын асуудлаар дотоодын зөвлөх болон төслийн захирлын томилсон холбогдох мэргэжилтнүүдтэй өдөр тутам хамтран ажиллана.

Захиалагч нь гадаад зөвлөхөд дотоодын зөвлөх болон гэрээнд заасан бүтээгдэхүүнийг хүлээн авах ажилтнуудтай ажиллахад нь ТХН дээр ажлын өрөөгөөр хангана.